



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/17

Чингис хот

Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6, 22.8, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 05-ны А/373 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгийн үед үүрэг гүйцэтгэх Иргэний бүртгэл, мэдээлэл, статистик судалгааны мэргэжлийн ангийг байгуулсугай.
2. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар томилсугай.
3. Иргэний бүртгэл, мэдээлэл, статистик судалгааны мэргэжлийн анги нь гамшиг, аюулт үзэгдлийн үед шаардлагатай хүн амын судалгаа мэдээ, мэдээлэл, лавлагааг гаргах, мал амьтан эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмж, хүч хэрэгслийн тооцоо судалгаа гаргах арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг мэргэжлийн ангийн дарга болон гишүүдэд даалгасугай.
4. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг мэргэжлийн ангийн дарга /Б.Төрхүү/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

Иргэний бүртгэл мэдээлэл, статистик судалгааны  
мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн

Д/д	Овог нэр	Мэргэжлийн ангийн томилгоо	Одоогийн албан тушаал
1	Буриад Төрхүү	Мэргэжлийн ангийн дарга	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
2	Түмэн Өлзийсүрэн	Орлогч буюу сургалт сурталчилгаа хариуцсан ажилтан	Статистикийн хэлтсийн дарга
3	Жамцдорж Энхбат	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан	АЗДТГ-ын Компьютерийн технологи, программ хангамж хариуцсан мэргэжилтэн
4	Ганзориг Ангараг	Гамшгаас хамгаалах нөөц, хангалт хариуцсан ажилтан	Статистик Судлаач
5	Лхагвасүрэн Будсүрэн	Аюулгүй байдал хариуцсан ажилтан	Архивч, сүлжээний инженер
6	Нацагдорж Дагвадорж	Иргэний бүртгэл мэдээллийн бүлгийн ахлагч	Улсын бүртгэгч
7	Бибиш Сийлэгмаа	Лавлагаа, мэдээлэл хариуцсан бүртгэгч	Улсын бүртгэгч
8	Дондов Эрдэнэбаясах	Туслах ажилтан	Архивын үйлчлэгч
9	Цэгмид Ганцогт	жолооч	Улсын бүртгэлийн хэлтсийн жолооч
10	Цог Батхишиг	Статистик мэдээллийн бүлгийн ахлагч	Статистикийн мэргэжилтэн
11	Гансүрэн Сэдэдмаа	Бүртгэл мэдээлэл хөтлөгч	Статистикийн мэргэжилтэн
12	Гантулга Одбаясгалан	Судалгааны ажилтан	Статистик судлаач
13	Довжоо Баттулга	Туслах ажилтан	АЗДТГ-ын Дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн